

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД,  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД,  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

---

2022 оны .... дугаар  
сарын ....-ны өдөр

Дугаар ...../...../...../

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 20.3 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Хамтарсан багийн ажиллах, түүнийг санхүүжүүлэх журам”-ыг нэгдүгээр, “Хамтарсан багаас үзүүлэх үйлчилгээний маягт”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, салбар зөвлөл, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, аймаг, нийслэл, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /хэлтэс/, Цагдаагийн газар /хэлтэс/, Эрүүл мэндийн газар, аймаг, нийслэл, дүүргийн Эрүүл мэндийн төв, бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Хамтарсан багийн үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөв, холбогдох салбарын төсөвт тусгаж, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрт хамруулах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Н.Баярмаа/-т, Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Э.Энхтуяа/-т, Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба /Д.Номинчимэг/-д, Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн тусламжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Баярболд/ -т тус тус даалгасугай.

5. Энэ журам гарсантай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/173, А/259, А/380 дугаар хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙД

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД

ЭРҮҮЛ МЭНДИЙН  
САЙД

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй,  
дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2022  
оны ..... сарын....-ний өдрийн...../...../.....  
тоот хамтарсан тушаалаар баталсан журмын  
нэгдүгээр хавсралт

## **ХАМТАРСАН БАГИЙН АЖИЛЛАХ, ТҮҮНИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэ журмын зорилго нь аймаг, сум баг, дүүрэг, хороонд “Хамтарсан баг”-ийн үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалт, гишүүдийн гүйцэтгэх чиг үүрэг, санхүүжилт, тайлан, үйл ажиллагаанд тавих хяналтыг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүүхэд хамгааллын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Хамтарсан баг нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг, 41 дүгээр зүйл, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т заасан үйлчилгээг анхан шатанд үзүүлнэ.

1.3. Хамтарсан баг нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан үйлчилгээг хүчирхийллийн хохирогчид үзүүлэх бөгөөд шаардагдах зардлыг улс, орон нутгийн болон салбарын төсвөөс санхүүжүүлнэ.

1.4. Хамтарсан багаас үзүүлэх үйлчилгээний зардлыг Нийгмийн ажлын үйлчилгээний нийтлэг шаардлага MNS 6949:2021 стандарт, Нийгмийн ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрэмд заасан хэм хэмжээнд нийцүүлэн, тохиолдлын бүрдэл, үйлчилгээний үр дүн, Нийгмийн ажил, үйлчилгээний мэдээллийн санд нэгтгэн баталгаажуулсаныг тус тус үндэслэн олгоно.

1.5. Хамтарсан багаас үзүүлэх үйлчилгээний зардлыг тухайн аймаг/дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл жил бүрийн орон нутгийн төсөвт тусган батлуулах арга хэмжээг авна.

1.6. Хамтарсан баг нь гэр бүл, нийгмийн орчинд хүүхэд, гэр бүлийн эсрэг хүчирхийлэл, гэмт хэрэг, зөрчил, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, мэдээлэл хүлээн авах, илрүүлэх, шалгах, хүчирхийллийг таслан зогсоох, нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулгүй байдлыг хангах, хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй хүнийг мэргэшүүлэх сургалтад хамруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эрүүл мэндийн шаардлагатай үйлчилгээ үзүүлэх, гэр бүлд нь дэмжлэг үзүүлэх замаар нөхөн сэргээх, шаардлагатай бусад үйлчилгээнд холбон зуучилж, үр дүнг хянана.

1.7. Хамтарсан баг нь хэсгийн ахлагч, цагдаагийн албан хаагч, иргэний бүртгэлийн ажилтантай хамтран ажиллах, шаардлагатай тохиолдолд дохионы хэлний хэлмэрч, орчуулагч, сэтгэл засалч, хүний эрх, хүүхдийн эрх, хамгааллын асуудлаар мэргэшсэн магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллага,

мэргэжилтний дэмжлэг, туслалцааг аймаг, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /хэлтэс/-т уламжлан авч болно.

## **Хоёр. Хамтарсан багийн удирдлага, зохион байгуулалт, дэмжлэг**

### **2.1. Хамтарсан багийн удирдлага, зохион байгуулалт:**

2.1.1. Сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн орон нутагт ажиллах Хамтарсан багийг сум/баг, хорооны Засаг дарга, сургуулийн, хүүхэд, гэр бүлийн, хөдөлмөр, халамжийн нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэн, өрхийн эмч, цагдаагийн алба хаагч болон энэ чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагын төлөөллийн бүрэлдэхүүнтэй байгуулна.

2.1.2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т заасан албан тушаалын нэрээр Хамтарсан багийн бүрэлдэхүүнийг батална.

2.1.3. Шаардлагатай тохиолдолд Хамтарсан багийн бүрэлдэхүүнд өрхийн эмнэлгийн дарга, эсхүл эрүүл мэндийн нийгмийн ажилтан, сургуулийн сэтгэл зүйч, цэцэрлэгийн арга зүйчийг оролцуулж болно.

2.1.4. Хамтарсан багийг сум, хороо/баг/-ийн Засаг дарга /цаашид “багийн ахлагч” гэх/ ахалж, багийн тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах үүргийг хүлээнэ.

2.1.5. Хамтарсан багийн нарийн бичгийн даргаар суманд Засаг даргын Тамгын газрын нийгмийн бодлогын мэргэжилтэн, хороонд хөгжлийн нийгмийн ажилтан, багт багийн нийгмийн ажилтан /цаашид “нарийн бичгийн дарга” гэнэ/ ажиллана.

2.1.6. Нарийн бичгийн дарга нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасан үүргийг хүлээхээс гадна багийн гишүүдийн оролцоо, үр дүнг хянах үүрэг хүлээж, багийн ажлын үр дүнгийн тайлан, үзүүлсэн үйлчилгээг Нийгмийн ажил, үйлчилгээний мэдээллийн санд бүртгэнэ.

2.1.7. Хамтарсан багийн гишүүд мэргэжлийн ёс зүйг баримтлан, ажил үүргээ хариуцлагатай гүйцэтгэж, багийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулна.

2.1.8. Хамтарсан багийн хурал нь төлөвлөсөн болон шуурхай хэлбэртэй байна. Төлөвлөсөн хурал нь тогтсон цаг хугацаанд, шуурхай хурал нь нөхцөл байдлыг үндэслэн багийн ахлагч, эсхүл нарийн бичгийн даргын зарласнаар явагдана. Ажлын бус цагт зарласан хурлыг багийн ахлагчид заавал танилцуулж, зөвшилцөх, өгсөн үүрэг, чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээ авна.

2.1.9. Хамтарсан багийн төлөвлөсөн хурал 51-ээс дээш хувийн ирцтэй тохиолдолд хүчин төгөлдөр болох ба шийдвэр нь хуралд оролцсон гишүүд журмын

хавсралтад заасан хурлын тэмдэглэлд гарын үсэг зурснаар баталгаажна. Хурлын тэмдэглэлд тухайн холбогдох баримт бичгийн хувийг хавсаргаж болно.

2.1.10. Хамтарсан баг нь хүчирхийллийн болзошгүй эрсдэлд байгаа хүүхэд, гэр бүлийг илрүүлэх судалгаанд үндэслэн жилийн ажлын төлөвлөгөө, төсвийг боловсруулж, батлуулна.

2.1.11. Хамтарсан баг нь хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хагас, бүтэн жилээр төлөвлөх ба үр дүнгийн тайланг Нийгмийн ажил, үйлчилгээний мэдээллийн санд бүртгүүлж, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, орон нутгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

2.1.12. Хамтарсан багийн гишүүдэд олгох урамшуулалд шаардагдах зардлыг аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаанд шаардагдах зардлын төсвийн хүрээнд Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд өргөн мэдүүлэх ба Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь төсөвт тусган шийдвэрлэнэ.

2.1.13. Хамтарсан багийн гишүүдэд урамшуулал олгох эсэх асуудлыг Хамтарсан багийн нарийн бичгийн дарга, багийн ахлагчтай зөвшилцөж, гишүүдийн идэвх санаачилга, оролцоо, хурлын ирцэд үндэслэн нэг цагт ногдох хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож, улирал бүр үндсэн цалин дээр олгоно.

2.1.14. Хамтарсан багийн нарийн бичгийн дарга буюу тохиолдлыг шийдвэрлэсэн багийн гишүүнд урамшуулал олгохдоо дараах хүчин зүйлийг харгалзан үзэх бөгөөд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны А/23, А/27 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-ыг баримтална. Үүнд:

- 2.1.14.1. хохирогчид үзүүлэх үйлчилгээний төлөвлөгөөний хэрэгжилт;
- 2.1.14.2. шийдвэрлэсэн тохиолдлын тоо;
- 2.1.13.3. хуралдааны тэмдэглэл;
- 2.1.14.4. гэр бүлтэй ажилласан, эргэх холбоо үүсгэсэн тохиолдлын тоо;
- 2.1.14.5. хүчирхийлэл үйлдэгчид сануулга өгсөн шаардлага тавьсан, хариуцлага хүлээлгэсэн тоо;
- 2.1.14.6. урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн сургалт, нөлөөллийн арга хэмжээний тоо.

## **2.2. Хамтарсан багт үзүүлэх дэмжлэг:**

2.2.1. Аймаг/ нийслэл, дүүргийн нийгмийн бодлогын хэлтэс нь Хамтарсан багийн үйл ажиллагааг бодлогын хүрээнд мэргэжил, арга зүйн удирдлага, салбар дундын зохицуулалтаар хангаж, идэвхжүүлэн дэмжлэг үзүүлэх ба үйл

ажиллагааны үр дүнд хяналт тавьж, дээд шатны удирдлага /Засаг дарга/-д танилцуулна.

2.2.2. Засаг дарга Хамтарсан багийн удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах, үйл ажиллагаанд санхүүгийн болон нийгмийн ажилтныг хохирогчтой ганцаарчлан уулзах өрөө, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх ба бусад дэмжлэг үзүүлнэ.

2.2.3. Аймаг/ нийслэл, дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, орон нутгийн Хүүхдийн төлөө зөвлөл, хүүхэд, гэр бүлийн хөгжил, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр, халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, цагдаагийн байгууллага нь Хамтарсан багийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллана.

2.2.4. Хамтарсан баг нь шаардлагатай тохиолдолд хэсгийн ахлагч, олон нийтийн цагдаа иргэний бүртгэлийн ажилтан, сэтгэл зүйч, хэлмэрч, орчуулагч, болон хүний эрх, хүүхдийн эрх, хамгаалал, хүчирхийллийн асуудлаар мэргэшсэн, магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллагын дэмжлэг, туслалцааг авч болно.

## **Гурав. Хамтарсан багийн гишүүдийн чиг үүрэг**

### **3.1. Хамтарсан багийн ахлагч:**

3.1.1. Хамтарсан багт хандсан дуудлага, мэдээллийг холбогдох маягтын дагуу хүлээн авч, бүртгэлд авна.

3.1.2. Хүчирхийллийн эрсдэлтэй мэдээлэл хүлээн авсан сум/ баг, хорооны Засаг дарга Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 24.1-д заасны дагуу таслан зогсоох арга хэмжээг шуурхай авч, холбогдох журмын дагуу насанд хүрсэн хохирогчийн аюулгүй байдлын хамгаалалтыг хэрэгжүүлэх, хүүхдийг тусгай хамгаалалтаар тус тус хангаж ажиллана.

3.1.3. Хамтарсан багаас үзүүлэх тохиолдлын үйлчилгээний төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ, үр дүн, хувийн хэргийн бүрдлийг хянаж, гарын үсэг зурж, баталгаажуулна.

3.1.4. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хохирогч хүүхдэд үзүүлэх хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг Хүүхэд хамгааллын тухай хууль болон холбогдох журмын дагуу удирдан зохион байгуулна.

3.1.5. Хамтарсан багаас хүүхдэд үзүүлэх үйлчилгээний зардлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны А/23, А/27 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-ын дагуу тооцно.

3.1.6. Насанд хүрсэн үйлчлүүлэгчийн хүсэлтээр Хамтарсан багаас үзүүлэх үйлчилгээг зогсоох тохиолдолд аюулын эрсдлийн үнэлгээнд тулгуурлан хохирогчтой ганцаарчилсан ярилцлага хийсний үндсэн дээр эцсийн шийдвэрийг гаргана. Үйлчилгээний үр дүнг үнэлэх, хувийн хэргийг хаахдаа холбогдох баримтыг хавсарган, хянаж, гарын үсэг зурж, баталгаажуулна.

3.1.7. Хамтарсан багийн гишүүдэд олгох шагнал, урамшуулал, шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлэх талаар дараагийн шатны байгууллагад уламжилж, шийдвэрлүүлнэ.

3.1.8. Хамтарсан багийн гишүүдийг удирдлага арга зүйгээр хангах, туслалцаа үзүүлэх, мэргэжлийн байгууллагад холбон зуучлах, шаардлагатай тоног төхөөрөмж, ганцаарчилсан уулзалт хийх өрөөгөөр хангана.

## **3.2. Нарийн бичгийн дарга:**

3.2.1. Хамтарсан багт хандсан дуудлага, мэдээллийг цагдаагийн алба хаагч болон багийн ахлагчийн эзгүй байх хугацаанд хүлээн авч, холбогдох маягтын дагуу бүртгэл хөтлөн, энэ тухай цагдаагийн байгууллага, Хамтарсан багийн ахлагчид мэдээлнэ.

3.2.2. Гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүчирхийлэл гарахад хүргэж буй эрсдэл, тохиолдлыг эрт илрүүлэх зорилгоор иргэд, олон нийт, байгууллага, аж ахуйн нэгжид хүчирхийллийг үл тэвчих хандлага, мэдлэгийг нэмэгдүүлэх нөлөөллийн ажлыг харьяалах нутаг дэвсгэрийн хүн ам, эрсдэлт хүчин зүйлийн судалгааны үр дүнд үндэслэн хэрэгжүүлнэ.

3.2.3. Хүчирхийллийн хохирогчид нөхцөл байдлын үнэлгээ хийж, маягтыг бөглөнө.

3.2.4. Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх тухай журамд заасны дагуу хүүхдийн эсрэг хүчирхийллийн дуудлага мэдээлэл хүлээн авах, бүртгэх, дуудлага мэдээллийн дагуу хохирогч хүүхдийн аюулгүй байдлыг хангах, нөхцөл байдлыг тодорхойлох, үйлчилгээний тохиолдлын төлөвлөгөө гаргах, хүүхэд хамгааллын шуурхай тусламж болон хамгаалах нөхөн сэргээх түвшний үйлчилгээг хүүхдийн гэр бүлийн болон гэр бүлээс тусдаа орчинд үзүүлнэ.

3.2.5. Шаардлагатай тохиолдолд хүүхэд хамгааллын шуурхай тусламжийн, хамгаалах нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх түвшний үйлчилгээг мэргэшсэн магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллагаар үзүүлэх ажлыг зохицуулах, холбон зуучлах, тохиолдлын төлөвлөгөөний дагуу үйлчилгээ хүргэж буй эсэхийг үнэлж, тохиолдлыг хаах ажлыг хариуцна.

3.2.6. Аюулын зэргийн болон нөхцөл байдлын үнэлгээгээр өндөр эрсдэлтэй гарсан тохиолдолд аюулгүй байдлыг нь хангах, шуурхай тусламжийн түвшний үйлчилгээг үзүүлж, аймаг, дүүрэг, эсхүл нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн

асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэмжлэг, туслалцааг авч, хамтран ажиллана.

3.2.7. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу хохирогчид сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөө өгөх, шаардлагатай гэж үзвэл Хамтарсан багийн хурлын шийдвэрээр уг хуулийн 38.1.1, 39.3-т заасан үйлчилгээнд холбон зуучилж, эргэх холбоотой ажиллана.

3.2.8. Хохирогчийн амь нас, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө, аюулын зэргийн үнэлгээ өндөр гарсан тохиолдолд хүчирхийлэгчийг хяналтад авах, тусгаарлах арга хэмжээг цагдаагийн алба хаагчтай хамтран хэрэгжүүлнэ.

3.2.9. Хохирогчийг түр хамгаалах байранд, шаардлагатай тохиолдолд хүүхдийг төрөл садны асрамж эсхүл халамж, асрамжийн төвд шилжүүлнэ.

3.2.10. Нарийн бичгийн дарга нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасан үүргийг хүлээхээс гадна багийн гишүүдийн оролцоо, үр дүнг хянах үүрэг хүлээж, багийн ажлын үр дүнгийн тайланг Нийгмийн ажил, үйлчилгээний мэдээллийн санд тогтсон хугацаанд бүртгэнэ.

3.2.11. Хамтарсан багаас Түр хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төвд холбон зуучилсан хохирогчийн мэдээллийг хамгаалах байрны нийгмийн ажилтан мэдээллийн сан /etsulamj.mn/-д бүртгэнэ.

3.2.12. Гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллийн хохирогчид орчуулагч, дохионы хэлмэрч, итгэмжлэгдсэн төлөөлөгч ажиллуулах шаардлагатай бол аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага, холбогдох төрийн болон иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллана.

3.2.13. Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх сайн дурын болон албадан сургалтыг зохион байгуулахад аймаг, дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөл нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 44.2-т зааснаар магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллагатай гэрээ байгуулж ажиллаж болно.

3.2.14. Хүчирхийллийн байнгын харилцаатай гэр бүлд үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээг үйлчлүүлэгчийн хүсэлтээр үргэлжлүүлж болно.

3.2.15. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалалтад байх хугацаанд Хамтарсан багийн гишүүд болон Нэг цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байрны мэргэжилтэн нь хохирогчийн ажлын байрыг хадгалах, хөдөлмөрийн хөлсийг нөхөн тооцуулах чиглэлээр тухайн ажил олгогчид мэдэгдэж, үйлчилгээний нууцлалыг хадгалах үүргийг байгууллагын хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн, үйлдвэрчний эвлэлтэй хамтран Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4.1.15-д заасны дагуу хүлээнэ.

3.2.16. Нарийн бичгийн дарга сар бүр Хамтарсан багийн үйл ажиллагаанд хяналт тавих ба багийн ахлагч болон гишүүдэд танилцуулж, шаардлагатай зөвлөмж, анхааруулгыг өгнө.

### **3.3. Өрх, сумын эмч болон эмнэлгийн мэргэжилтэн:**

3.3.1. Хамтарсан багт хандсан дуудлага, мэдээллийг цагдаагийн албан хаагч болон багийн ахлагчийн эзгүй байх хугацаанд нийгмийн ажилтан, түүний эзгүйд чиг үүргийг түр орлон гүйцэтгэж байгаа багийн гишүүн холбогдох маягтын дагуу хүлээн авч, бүртгэлд авна.

3.3.2. Хамтарсан багийн гишүүн өрхийн эмч нь Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 5.4-д заасны дагуу үр дүнг хагас бүтэн жилээр үнэлүүлэх, ингэхдээ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг заавал тайлагнана.

3.3.3. Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх бүхий л явцад хүчирхийллийн хохирогч болсныг сэжиглэсэн, таамагласан, мэдсэн тохиолдолд мэдээллийг багийн ахлагчид, багийн ахлагчийн эзгүйд нарийн бичгийн даргад мэдэгдэнэ.

3.3.4. Хохирогчийн эрүүл мэндийн байдлыг тогтоож, мэргэжлийн дүгнэлт гаргана.

3.3.5. Хохирогчийг хүлээн авч, үйлчилгээг төлөвлөх, үзүүлэх, үнэлэх, холбон зуучлах, үйлчилгээ дуусгавар болох хүртэлх бүхий л үе шатанд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлнэ.

3.3.6. Гэр бүлийн хүчирхийлэл, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулна.

3.3.7. Хохирогчийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 27, 37 дугаар зүйл, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тусламж, үйлчилгээнд хамруулах, шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн дараагийн шатанд холбож, хяналт тавьж ажиллана.

3.3.8. Хохирогчийн осол гэмтэл, өвчлөлийн шалтгааныг тэмдэглэн баримтжуулж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний явц, үр дүнгийн талаарх мэдээллийг нарийн бичгийн даргад өгч, үйлчлүүлэгчийн баримтад хавсруулна.

### **3.4. Сургуулийн нийгмийн ажилтан:**

3.4.1. Хамтарсан багт хандсан дуудлага, мэдээллийг цагдаагийн алба хаагч болон багийн ахлагчийн эзгүй байх хугацаанд нийгмийн ажилтан, түүний эзгүйд чиг үүргийг түр орлон гүйцэтгэж байгаа багийн гишүүн холбогдох маягтын дагуу хүлээн авч, бүртгэлд авна.

3.4.2. Хамтарсан багт ирсэн дуудлага, мэдээллийн дагуу шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай тохиолдолд бусад үйлчилгээнд холбон зуучилна.

3.4.3. Хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй иргэн, хүүхэд гэр бүлд чиглэсэн шуурхай тусламжийн, нөхөн сэргээх урьдчилан сэргийлэх, нийгмийн ажил үйлчилгээг холбогдох байгууллагатай хамтран үзүүлнэ.

3.4.4. Хүүхдийн эсрэг болон гэр бүлийн хүчирхийлэлд хүргэж болох эрсдэл, тохиолдлыг эрт илрүүлэх зорилгоор олон нийт, байгууллага, иргэдийн хүчирхийллийг үл тэвчих хандлага, мэдлэгийг нэмэгдүүлэх кампанит ажлыг харьяалах нутаг дэвсгэрийн судалгаа, нөхцөл байдалд үндэслэн хэрэгжүүлнэ.

3.4.5. Хүчирхийллийн эрсдэлтэй гэр бүлийн гишүүдийг хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэх, насанд хүрэгчдийн зөрчлийг шийдвэрлэх зэрэг гэр бүлийг дэмжих, нөхөн сэргээх сургалт, зөвлөгөө, дэмжлэгт хамруулна.

3.4.6. Сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, цэцэрлэгийн арга зүйч нь Боловсролын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан үйлчилгээг үзүүлэх, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/612 дугаар тушаалаар батлагдсан “Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг суурь боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах” журам, цэцэрлэг, сургуулийн Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлж ажиллана.

3.4.7. Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга, гэр бүлийн боловсролыг нэн тэргүүнд эрсдэлт болон зорилтот гэр бүлд олгох, амьдралд хэвшүүлэх цуврал ажлыг зохих талуудтай, эсхүл мэргэшсэн сургагч багштай хамтран зохион байгуулна.

3.4.8. Хамтарсан багийн нийгмийн ажилтны чиг үүргийг гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн шийдвэрлэсэн тохиолдлын үр дүнг Нийгмийн ажилтны мэдээллийн санд оруулсан, баримтжуулсан, баримт бүрдүүлсэн эсэхээс хамаарч урамшуулал олгоно.

### **3.5. Халамжийн нийгмийн ажилтан:**

3.5.1. Хамтарсан багт хандсан дуудлага, мэдээллийг цагдаагийн алба хаагч болон багийн ахлагчийн эзгүй байх хугацаанд нийгмийн ажилтан, түүний эзгүйд чиг үүргийг түр орлон гүйцэтгэж байгаа багийн гишүүн холбогдох маягтын дагуу хүлээн авч, бүртгэлд авна.

3.5.2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 40.1-д заасны дагуу хохирогчийг нийгмийн халамжийн холбогдох үйлчилгээнд, Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.2.22-т заасны дагуу хүчирхийлэлд өртсөн хүүхдийг асран хамгаалах, харгалзан дэмжих үйлчилгээ үзүүлж байгаа хүнийг асаргааны тэтгэмж олгох үйлчилгээнд хамруулна.

3.5.3. Хохирогчийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу холбон зуучлахад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/73 дугаар тушаалыг мөрдөж ажиллана.

3.5.4. Хохирогчийг Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах зэрэг нийгмийн амьдралд оролцох оролцоог дээшлүүлэх хөтөлбөрт хамруулна.

3.5.6. Хүчирхийлэл байнга үйлдэгддэг, эсхүл эрсдэлтэй гэр бүлийн гишүүдийг нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн эсэхийг холбогдох журмын дагуу тогтоох, хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх бөгөөд зан үйл өөрчлөх сургалт, сайн дурын сургалтад хамруулах арга хэмжээг холбогдох албан хаагчтай хамтран хэрэгжүүлнэ.

3.5.7. Гэр оронгүй хүчирхийллийн хохирогчийг Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.1.5-д заасны дагуу орон гэртэй болгох, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хохирогчийн нөхцөл байдлын үнэлгээнд үндэслэн асрамж, халамжийн байгууллагад шилжүүлэх асуудлыг Хамтарсан багийн ахлагч тухайн шатны Засаг даргад уламжлан шийдвэрүүлнэ.

3.5.8. Хохирогчийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд шаардлагатай тохиолдолд хамруулна.

### **3.6. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн нийгмийн ажилтан:**

3.6.1. Хамтарсан багт хандсан дуудлага, мэдээллийг цагдаагийн алба хаагч болон багийн ахлагчийн эзгүй байх хугацаанд нийгмийн ажилтан, түүний эзгүйд чиг үүргийг түр орлон гүйцэтгэж байгаа багийн гишүүн холбогдох маягтын дагуу хүлээн авч, бүртгэлд авна.

3.6.2. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдэхэд хүргэж болох эрсдэл, тохиолдлыг эрт илрүүлэх зорилгоор олон нийт, байгууллага, иргэдийн хүчирхийллийг үл тэвчих хандлага, мэдлэгийг нэмэгдүүлэх нөлөөллийн ажлыг харьяалах нутаг дэвсгэрийн судалгаа, нөхцөл байдалд үндэслэн хэрэгжүүлнэ.

3.6.3. Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга, гэр бүлийн боловсролыг эрсдэлт болон зорилтот гэр бүлд олгох, амьдралд хэвшүүлэх цуврал ажлыг зохих талуудтай эсхүл мэргэшсэн сургагч багштай хамтран зохион байгуулна.

3.6.4. Хохирогчийн аюулын зэргийн болон нөхцөл байдлын үнэлгээгээр өндөр эрсдэлтэй гарсан тохиолдолд нийгмийн ажилтантай хамтран ажиллана.

3.6.5. Хүчирхийллийн харилцаатай гэр бүлийн хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэх, насанд хүрэгчдийн зөрчлийг шийдвэрлэх зэрэг гэр бүлийг дэмжих, нөхөн сэргээх сургалт, зөвлөгөө, дэмжлэгт хамруулна.

3.6.6. Хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхдийг түүний хүсэл сонирхолд нийцүүлэн дугуйлан, клуб, секц, хотын үзвэр, аялал, хөгжлийн хөтөлбөр зэрэг нийгэмшүүлэх, амьдрах ухаанд сургах хөтөлбөрт хамруулна.

3.6.7. Хамтарсан багийн шийдвэрээр хүчирхийллийн хохирогч хүүхэд, насанд хүрэгчийн хүсэлтээр хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор итгэмжлэгдсэн төлөөлөгчийг /хууль ёсны төлөөлөгч/ томилон ажиллуулах хүсэлтийг аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

### **3.7. Цагдаагийн алба хаагч:**

3.7.1. Хамтарсан багт хандсан дуудлага, мэдээллийг цагдаагийн албан хаагч болон багийн ахлагчийн эзгүй байх хугацаанд нийгмийн ажилтан хүлээн авч, холбогдох маягтын дагуу бүртгэл хөтлөн, энэ тухай цагдаагийн байгууллага, Хамтарсан багийн даргад мэдээлнэ.

3.7.2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1, 39.2-т заасны дагуу хохирогчид эрх зүйн туслалцааг үзүүлнэ.

3.7.3. Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг тусгай хамгаалалтаар хангахдаа Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/39 дүгээр тушаалыг мөрдөж ажиллана.

3.7.4. Хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй гэр бүлийг илрүүлэхэд хэсгийн ахлагч, олон нийтийн цагдаа, иргэдийн дэмжлэгийг авч болно.

3.7.5. Гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй дуудлага, мэдээлэлд очсон Цагдаагийн албан хаагч шаардлагатай гэж үзвэл зураг авах, дуу дүрсний бичлэг хийх, зарим баримтыг хувилж авах зэргээр хүчирхийллийн тохиолдлыг баримтжуулна.

3.7.6. Хамтарсан багийн ахлагч болон цагдаагийн алба хаагч нь хохирогчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 33.1.1, 34 дүгээр зүйлд заасан аюулгүй байдлын хамгаалалтыг хэрэгжүүлнэ.

3.7.7. Хүчирхийлэл үйлдэгчийг зан үйлд нөлөөлөх сайн дурын болон албадан сургалтад хамруулах арга хэмжээг Хамтарсан багийн ахлагч зохион байгуулж, цагдаагийн албан хаагч хамтран хэрэгжүүлэх.

3.7.8. Хүчирхийллийн хохирогч хүүхдэд хууль, эрх зүйн туслалцаа үзүүлж, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороотой хамтран ажиллана.

3.7.9. Сум/баг, хорооны нутаг дэвсгэрт гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой удаа дараа өгсөн дуудлага, мэдээллийн талаарх судалгааг сар бүр гаргаж, Хамтарсан багаар хэлэлцүүлэн, хяналт тавих, хариу арга хэмжээ зохион байгуулж ажиллана.

3.7.10. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагын сэтгэл зүйч эзгүй байх хугацаанд цагдаагийн байгууллагын сэтгэл зүйч болон сургуулийн сэтгэл зүйчээр үйлчлүүлэгчийн сэтгэл санааны байдал, эрсдлийн түвшинг харгалзан сэтгэл зүйн дэмжлэг үзүүлнэ.

ТӨСӨЛ

## **Дөрөв. Хамтарсан багаас үзүүлэх үйлчилгээний жишиг зардлыг төлөвлөх, санхүүжүүлэх**

### **4.1. Хамтарсан багаас үзүүлэх үйлчилгээний зардал:**

4.1.1. Хамтарсан багийн үйл ажиллагаанд шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсөв, хуулиар зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

4.1.2. Хамтарсан багийн тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг санхүүжүүлэх зардлыг аймаг, дүүргийн Засаг дарга орон нутгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө болон төсөвт тусгаж, шийдвэрлэнэ.

4.1.3. Тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь Засаг даргын өргөн мэдүүлсэн төсвийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-т заасны дагуу хэлэлцэн батална.

4.1.4. Хамтарсан багаас үзүүлэх урьдчилан сэргийлэх үйлчилгээний зардлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны А/23, А/27 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-ыг үндэслэн тооцож, аймаг, дүүрэг, нийслэлийн Засаг дарга, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

4.1.5. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлсэн хамгааллын үйлчилгээний зардлыг үйлчилгээ тус бүрээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны А/23, А/27 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-ыг үндэслэн тооцож, аймаг, дүүрэг, нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага санхүүжүүлнэ.

4.1.6. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид /насанд хүрэгч/ үзүүлсэн хамгааллын үйлчилгээний зардлыг үйлчилгээ тус бүрээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны А/23, А/27 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-ыг үндэслэн тооцож, аймаг, дүүрэг, нийслэлийн Засаг дарга, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

### **4.2. Урьдчилсан сэргийлэх үйлчилгээний зардал:**

4.2.1. Урьдчилсан сэргийлэх түвшний үйлчилгээний зардлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны А/23, А/27 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-ыг жишиг болгон тооцож санхүүжүүлнэ.

4.2.2. Хамтарсан багаас үзүүлэх урьдчилсан сэргийлэх үйлчилгээний зардлын бүрэлдэхүүнд сургагч багшийн хөлс, цайны зардал, сургалтын

хэрэглэгдэхүүн, шаардлагатай тохиолдолд сургагч багшийн томилолтын зардал багтана.

4.2.3. Хүүхдийг эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний санхүүжилтийг тухайн орон нутгийн хүүхдийн тоонд тулгуурлан тооцно.

4.2.4. Эцэг эх, гэр бүлд чиглэсэн хүний эрх, жендер, жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлын санхүүжилтийг орон нутгийн өрхийн тоонд тулгуурлан тооцно

4.2.5. Олон нийтэд чиглэсэн гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллийг үл тэвчих хандлага, соёлыг бэхжүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг тухайн орон нутгийн хүн амын тоонд тулгуурлан тооцно.

#### **4.2. Нөхцөл байдлын үнэлгээ хийх зардал:**

4.3.1. Нөхцөл байдлын үнэлгээ хийх зардлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны А/23, А/27 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-ыг үндэслэнэ.

4.3.2. Нөхцөл байдлын үнэлгээ хийх зардлын бүрэлдэхүүнд тохиолдлыг нээхэд шаардлагатай бичиг хэрэг, баримтжуулах, холбон зуучлах, унаа, харилцаа холбооны зардал багтана.

4.3.3. Нөхцөл байдлын үнэлгээний дагуу үзүүлсэн үйлчилгээний тоогоор санхүүжилт тодорхойлогдоно.

4.3.4. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 12.6 дахь заалтийн дагуу нөхцөл байдлын үнэлгээ хийсэн Хамтарсан багийн нийгмийн ажилтанд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны А/23, А/27 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-ын дагуу үндсэн цалин дээр урамшуулал тооцож олгоно.

#### **4.4. Холбон зуучлах үйлчилгээний зардал:**

4.4.1. Холбон зуучлах үйлчилгээний зардлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны А/23, А/27 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-ыг жишиг болгох ба шаардлагатай тохиолдолд доорх аргачлалыг баримтлан үйлчилгээний зардлыг тооцно. Үүнд:

4.4.1.1. Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6.8-д зааснаас бусад эрүүл мэндийн төлбөртэй эмчилгээ, үйлчилгээний зардалд төлбөрийн чадваргүй хохирогчид дэмжлэг үзүүлнэ.

4.4.1.2. Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах нөхцөл, журмыг хангасан үйлчлүүлэгчийг Нийгмийн халамжийн тухай хуулинд заасны дагуу үйлчилгээ үзүүлж, санхүүжүүлнэ.

4.4.1.3. үйлчлүүлэгч сэтгэл зүйн оношилгоо тогтоох, ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, гэр бүлийн сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг нарийн мэргэжлийн сэтгэл зүйчээс авч болох ба үйлчилгээний төлбөрийг үзүүлсэн үйлчилгээний баримтыг үндэслэн олгож, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Ерөнхий захирлын “Төлбөртэй тусламж, үйлчилгээ үзүүлэх тухай” 2019 оны А/73 тоот тушаалын хоёрдугаар хавсралтын “Төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт, үнийн тариф” дагуу олгоно.

4.4.2. Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх журмын дагуу үйлчлүүлэгчид сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээний төлөвлөгөө гаргах ба үйлчлүүлэгчийн нөхцөл байдал, үйлчилгээний үр дүнгээс хамаарч давтамжийг тооцно.

4.4.3. Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний үед бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх дундаж хугацаа хорин зургаан долоо хоног, бие махбод болон сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн хүүхдийн нөхөн сэргээх дундаж хугацаа долоон долоо хоног, үл хайхрах хүчирхийлэлд өртсөн хүүхдэд нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх дундаж хугацаа хоёр долоо хоног байна.

4.4.4. Түр хамгаалах байранд нөхөн сэргээх үйлчилгээний хоолны зардлыг байрлуулсан хоногоор тооцно.

4.4.5. Нөхөн сэргээх үйлчилгээний хүүхэд хамгааллын багцын зардлыг дунджаар 7 хоногийн зардал гэж тооцох ба үйлчилгээний багцад ариун цэврийн болон бага үнэтэй түргэн элэгдэх бараа, материалын зардал багтана.

#### **Тав. Хамтарсан багийн үйл ажиллагааны санхүүгийн баримт бүрдүүлэх**

5.1. Санхүүжилтийг сум/баг, хорооны Хамтарсан багийн гишүүн, аймаг, нийслэл, сум, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн байгууллагын ажилтанд олгож, зардлын хүснэгтэд бүртгэн, санхүүгийн анхан шатны баримтаар баталгаажуулна.

5.2. Гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэхээр магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж, үйлчилгээг санхүүжүүлж болно.

5.3. Үйлчилгээ үзүүлсэн магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллага нь үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн анхан шатны баримтаар баталгаажуулна.

5.4. Үйлчилгээ, үйл ажиллагааны зардлыг санхүүжилтийн бүртгэлийн маягтад бүртгэж, санхүүгийн анхан шатны баримт (кассын талон, такси, шатахууны баримт, гарын үсэг)-аар баримтжуулж, орон нутгийн холбогдох байгууллагад тайлагнана.

5.5. Санхүүгийн анхан шатны баримт авах боломжгүй тохиолдолд уг журмын хавсралтын маягууд болон, зураг, бичлэг зэргээр баримтжуулсан тайланг санхүүгийн баримтад хүлээн зөвшөөрч болно.

### **Зургаа. Хамтарсан багийн үйл ажиллагааны тайлагналт, хяналт-шинжилгээ, үнэлгээ**

6.1. Аймаг, дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь Хамтарсан багийн үйл ажиллагаа ба үйлчилгээ, санхүүгийн зарцуулалтад хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

6.2. Хамтарсан багийн үйл ажиллагааны болон санхүүгийн зарцуулалтад хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний нэгдсэн тайланг аймаг, дүүргийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хуралд танилцуулна.

6.3. Хамтарсан багийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, мэдээллийг нарийн бичгийн дарга нийгмийн ажил, үйлчилгээний мэдээллийн санд заавал оруулна.

